



## **ТЕНДЕРИЙН УРИЛГА**

Огноо: 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр  
Тендер шалгаруулалтын нэр: Автомашин нийлүүлэх  
Тендер шалгаруулалтын дугаар: CR-2012/01

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос орон нутаг дахь Монголбанкны салбарын ажлын хэрэгцээнд зориулан жийп ангиллын автомашин нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн бичиг баримтыг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 140,000 (нэг зуун дөчин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн турш хүчинтэй байна.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцохгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана.

Тендерийг 2012 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2012 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

### **МОНГОЛБАНК**

***Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, А байрны 1 давхар 2 тоот өрөө,***

***Утас: (976) 11-327048, Факс: (976) 11-311471***